



"АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ-Аудит" ХХК

“АЧИТ АЛХАБЫ” ХК

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон
Санхүүгийн аудитын тайлан

Улаанбаатар хот
2024

АГУУЛГА

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	2
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ.....	3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	8
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	11
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	12
ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ.....	12
ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС	15
ТОДРУУЛГА 4. БАРАА МАТЕРИАЛ	15
ТОДРУУЛГА 5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ.....	15
ТОДРУУЛГА 6. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР.....	15
ТОДРУУЛГА 7. ХУВЬЦААТ КАПИТАЛ.....	15
ТОДРУУЛГА 8. ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ.....	16
ТОДРУУЛГА 9. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ.....	16
ТОДРУУЛГА 10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ	16

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр /Оноосон нэр/	Монгол	"Ачит Алхабы" ХК
Компаний удирдлага	Х.Калимат	Захирал
Компанийн хаяг:	Монгол улс, Баян-Өлгий аймаг, Өлгий, Ховд, 0-0 Утас: (976)-99128814	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	210001001	
Регистрийн дугаар:	2003937	
Бүртгэгдсэн он сар	2006 оны 04-р сарын 05	
Үйл ажиллагааны чиглэл	Үр тариа болон бусад тариа тариалалт, Хүнсний ногоо, үрслэг тариалалт, Бөөний худалдааны бусад, Төмрийн дарханы төлбөрт үйлчилгээ, Гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	
Санхүү		Ерөнхий нягтлан бодогч
Ажилчдын тоо	.. орчим ажиллагсадтай	
Аудитын компани	"Ай Жэй Эй Эйч -Аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага	
Аудитын компанийн хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Copper plaza 502, 503 тоот Утас: 77450279, Факс: 976-77450279	

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 5-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Ачит Алхабы” Хувьцаат Компанийн /Компани гэх/ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хяриуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- ✓ Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ✓ Компаний санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ✓ Компаний нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.
- ✓ Санхүүгийн тайланг батлах өдөр болон энэхүү захидал зурагдах өдрийн хооронд санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц өөр үйл явдал гараагүй

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Ачит Алхабы” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.



[Handwritten signature]

/Нягтлан бодогч/



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Ачит Алхабы” ХК -ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Зөрчилгүй дүгнэлт

“Ачит Алхабы” ХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Ачит Алхабы” ХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлага энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу жилийн тайлан бэлтгэдэггүй.

Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас илэрхийлж байгаа мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, залилан болон алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлж мөрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан болон алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм. Ул үндэстэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа бүх буруу тайлагналыг үргэлж илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдлийг тодорхойлж үнэлэн, уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай нотолгоог олж авсан. Залилангаас үүдэлтэй материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах явдлууд орсон байж болно.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурьдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний

өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсч болох юм.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналт дахь зөрчил дутагдал, сул талуудыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлаар засаглах эрх бүхий этгээдтэй харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан компанийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2024.03.05

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган төгрөгөөр/	
	2022	2023
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	4,614.6	4,214.6
Авлага	-	-
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	-	-
Бараа материал	653.6	653.6
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,268.2	4,868.2
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	24,189.3	24,189.3
Биет бус хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,189.3	24,189.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,457.5	29,057.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,000.00	1,000.0
Цалингийн өглөг	-	-
Татварын өглөг	1,150.60	1,397.3
НДШ -ийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	1,200.0	1,500.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,350.6	3,897.3
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,350.6	3,897.3
Эздийн өмч		
Өмч / төрийн /		
Өмч / хувийн /	7,412.7	7,412.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	40,169.1	40,169.1
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(21,474.9)	(22,421.6)
Эздийн өмчийн дүн	26,106.9	25,160.2
Нийт өр төлбөр, өмчийн дүн	29,457.5	29,057.5




Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

ОРЛОГЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	2023
Борлуулалтын орлого	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-
Нийт ашиг (алдагдал)	-
Түрээсийн орлого	-
Хүүгийн орлого	-
Бусад орлого	-
Борлуулалт маркетингийн зардал	-
Ерөнхий ба удирдлагын зардал	946.7
Санхүүгийн зардал	-
Бусад зардал	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз)	-
Бусад ашиг /алдагдал/	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(946.7)
Орлогын татварын зардал	-
Татварын дараах ашиг (алдагдал)	(946.7)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(946.7)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган.төгрөгөөр/			
	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31	7,412.70	40,169.10	(21,474.99)	26,106.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	7,412.70	40,169.10	(21,474.99)	26,106.81
Өмчид гарсан өөрчлөлт	-	-		
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			(946.69)	(946.69)
Бусад дэлгэрэнгүй орлого				
2024 оны 12 сарын 31	7,412.70	40,169.10	(22,421.68)	25,160.12



Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн санхүүг хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мянган.төгрөгөөр/

2023

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-
Бусад мөнгөн орлого	-
Мөнгөн зарлагын дүн (-)	400.00
Ажилчдад төлсөн	-
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-
Бараа материал худалдан авахад төлсөн	-
Ашиглалтын зардалд төлсөн	400.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-
Хүүний төлбөрт төлсөн	-
Татварын байгууллагад төлсөн	-
Даатгалын төлбөрт төлсөн	-
Бусад мөнгөн зарлага	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(400.00)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	-
Хүлээн авсан хүүний орлого	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
Валютын ханшийн зөрүү	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(400.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,614.60
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,214.60



Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Ачит Алхабы” ХК нь үүсгэн байгуулагчийн 2012 оны 07 дүгээр сарын 24-ны өдрийн шийдвэр, баталсан дүрмийн дагуу 1 гишүүнтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан.

Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Үүнд:

- Үр тариа болон бусад тариа тариалалт
- Хүнсний ногоо, үрслэг тариалалт
- Бөөний худалдааны бусад
- Төмрийн дарханы төлбөрт үйлчилгээ
- Гэр ахуйн барааны засвар үйлчилгээ

ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

2.1 Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт цаашид (СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийг үндэслэн бэлтгэсэн.

2.2 Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компаний үйл ажиллагааны валют нь Монгол улсын үндэсний валют төгрөг юм.

2.3 Үнэлгээ

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэдэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн суурь

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурэль суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

2.5 Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын

тайлагнасан дүн зэрэгт нөлөөлөх үнэлгээ, таамаглал ба тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

2.6 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь харилцах дансуудаас бүрдэнэ. Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг.

2.7 Дансны өглөг

Компаний үндсэн үйл ажиллагаатай холбогдон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

2.8 Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

2.9 Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийлдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

2.10 Цэвэр хөрөнгө

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

2.11 Борлуулалт маркетингийн зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилсанаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Компанийн удирдлагын болон үндсэн үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрөх ба үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь бүртгэдэг.

А.Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

	2022	2023
Кассад байгаа бэлэн мөнгө (төгрөг)	4,614.6	4,214.6
Бэлэн мөнгөний дүн	4,614.6	4,214.6
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл /төгрөг/	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	4,614.6	4,214.6

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь төгрөгийн болон долларын харилцах дансуудаас бүрдсэн байна.

ТОДРУУЛГА 4. БАРАА МАТЕРИАЛ

	2022	2023
Бэлэн бүтээгдэхүүн	600.0	600.0
Хангамжийн материал	53.6	53.6
Бараа материалын дүн	653.6	653.6

ТОДРУУЛГА 5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	2022	2023
Барилга байгууламж	21,914.4	21,914.4
Машин тоног төхөөрөмж	1,961.4	1,961.4
Тавилга эд хогшил	313.5	313.5
Үндсэн хөрөнгийн дүн	24,189.3	24,189.3

ТОДРУУЛГА 6. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

	2022	2023
Дансны өглөг	1,000.0	1,000.0
ААНОАТ-ын өр	214.6	214.6
ОАТ -ын өр	296.0	542.7
НӨАТ-ын өр	640.0	640.0
Бусад богино хугацаат өр төлбөр	1,200.0	1,500.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,350.6	3,897.3

ТОДРУУЛГА 7. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	2022	2023
Хувийн өмч	7,412.7	7,412.7

Хувьцаат капиталын нийт дүн

7,412.7

7,412.7

Компаний хувь нийлүүлсэн хөрөнгө нь 7,412.7 мянган төгрөг байна.

ТОДРУУЛГА 8. ХУРИМТЛАГДСАН АШИГ /АЛДАГДАЛ/

	2022	2023
Тайлант үеийн ашиг	(21,474.9)	(22,421.6)
Хуримтлагдсан ашгийн дүн	(21,474.9)	(22,421.6)

ТОДРУУЛГА 9. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2023
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	246.7
Ашиглалтын зардал	700.0
Үйл ажиллагааны зардлын дүн	946.7

ТОДРУУЛГА 10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Тайлант хугацаан 946.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бэлтгэсэн:

Аудитор

Аудиторын туслах



Г. Энхмаа

Э. Нандин-Эрдэнэ